

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.12.10

Багахангай Эрүүл мэндийн төв

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
	Нэг. Чмг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтн талаарх мэдээллийн ил нээлттэй байдал		тод,
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	<p>Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, зохион байгуулалтын бүтцийг иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангаж байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж ажилласан ба мэдээллийг 5 удаа шинэчилсэн. Мөн байгууллагын вэб сайтад эрхэм зорилго, байгууллагын бүтэц, зорилтыг байршуулсан.</p> <p>Иргэдэд мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор “Эм Ар Эл” ХХК -тай хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагын вэб сайтыг 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд вэб сайтны үйл ажиллагааг тогтмолжуулан мэдээллийн баяжилтыг тухай бүр хийж ажиллаж байна.</p> <p>Байгууллагын пэйж цахим хуудсыг мэдээллийн баяжилтыг тогтмол хийж ажиллаж байна.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд хүргэх ил тод мэдээллийн самбарыг амбулаторийн хэсэгт байрлуулж мэдээллийн шинэчлэлыг 7 хоногт 2 удаа хийж ажиллаж байна.</p>	95
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<p>Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт хаяг байршлын мэдээллийг иргэд нээлттэй хүргэх зорилгоор амбулаторийн хэсэгт дуугүй хөтөч, мэдээллийн ил тод байдлыг самбарын мэдээллийг тогтмол шинэчилж байна. Цахим хуудсанд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн байршуулсан.</p>	90
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн	<p>Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит-аас ирүүлсэн албан шаардлагын дагуу ажлуудыг</p>	90

	санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	2024 оны АУДИТ-ын дүгнэлтээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган шилэн дансанд мэдээллийг сар бүийн 8-ны дотор цаг хугацаанд нь байршуулж ажиллаж байна.	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	<p>Мэдээлэл технологийн чиглэлээр гарсан тушаал, шийдвэр, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын цахим аюулгүй байдлыг ханган чиглэлээр НЭМГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд 1 ажилтанг хамруулсан.</p> <p>Мэдээлэл технологийн авуулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 11 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласнаар хэрэгжилт 88%-тай байна.</p> <p>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган</p>	88
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	<p>Байгууллагын удирдлага нийт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар нийт 33 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.</p> <p>Иргэдээс өргөдөл санал хүсэлтийг бичгээр, цахимаар, биечлэн уулзаж, нэгдсэн төв зэрэг хэлбэрээр хүлээн авсан.</p> <p>Шийдвэрлэлтийн хувь 100%, дундаж хоног 5 хоног байна.</p> <p>Нийт ирсэн 33 өргөдлийг ангилахад талархал 16 буюу 48,5%, санал 7 буюу 21,2%, хүсэлт 8 буюу 24,2%, гомдол 2 буюу 6,1%-тай байна.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын байдлаар</p> <ul style="list-style-type: none"> <li>- Саналын хуудсаар 359</li> <li>- Цахим санал хүсэлт -86</li> <li>- Ганцаарчилж уулзалт хийж хүлээн авсан 42 нийт 287 санал хүсэлтийг хүлээн авсан.</li> </ul> <p>Санал хүсэлтийн үр дүн зэрэг сэтгэл ханамж 88%-тай</p> <p>2024 оны мөн үетэй харьцуулахад эерэг сэтгэл ханамж 1,3%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан.</p>	90%

		<p>Үйлчлүүлэгчээс ирсэн нийт 63 санал хүсэлтээс богино хугацаанд санхүү зарцуулагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой 37 саналыг бүрэн шийдвэрлэж зохион байгуулалтыг хийсэн, хөрөнгө санхүү шаардагдах 19, боловсон хүчний талаар 7 тус тус санал бүртгэгдсэн. Иргэдэд өргөдөл, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар хариу мэдээлж ажилласан.</p>	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариусан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үзүүлэлт статистик сарын мэдээг байршуулах цэсийг байгууллагын вэб сайтанд оруулж мэдээллийг сар бүр байршуулж байна.</p> <p>Эмнэлгийн тусламж үйлчилгээ үндсэн үзүүлэлт, өвчлөлөөр ангилан 11 төрлийн мэдээг өдөр бүр, 7 хоног тутам, сараар нь нэгтгэн гаргаж НЭМГ, ХӨСҮТ, ХСҮТ зэрэг байгууллагуудад цаг хугацаанд тайлагнаж ажиллаж байна.</p>	80
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	<p>“Эм Ар Эл” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагын вэб сайтыг</p> <p>Байгууллагын вэб сайтын 6 үндсэн бүлэгтэй 17 дэд бүлэгтэй, нүүр хэсэгт байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл авах хэсгийг тохируулж өгсөн.</p> <p>Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэх зорилгоор байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд 34 төрлийн 573 мэдээлэл, зөвлөмжийг байршуулж түгээсэн ба хандалт 9856 байна.</p> <p>Байгууллагын цахим хуудас болон вэб сайтанд 8 төрлийн зөвлөмжийг байршуулж түгээж ажилласан ба хандалт 2450 байна.</p>	95
Хэсгийн дундаж хувь: 90			
<b>Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал</b>			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<p>Эрүүл мэндийн төв нь сул орон тооны зарыг НЭМГ-т 2 удаа, байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд 16 удаа, эрүүл мэндийн салбарын facebook нэгдсэн группэд тус бүр байршуулсан ба дүүргийн Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний хэлтэст тус бүр 9 удаа хүргүүлэн захиалгад оруулав</p>	95

2.2	Албан хаагч, ажилтны сонгон шалгаруулах журам	Байгууллагын даргын 2025 оны А/22 дугаар тушаалаар "Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам"-ыг шинэчлэн батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	95
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалыг өдөр утмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон баримтлан ажиллаж байна.</p> <p>Байгууллагын ёс зүйн хорооны хурлыг зохион байгуулах журам, ёс зүйн алдаа зөрчил бүртгэх журмыг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2025 онд ёс зүйн гомдол бүртгэгдээгүй, 2 зөрчил бүртгэгдснийг ёс зүйн салбар хорооны хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гаргаж ажилласан.</p> <p>Байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг ажилчдад ил тод байдлыг хангах зорилгоор дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн:</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жилийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг ажилчдад танилцуулсан.</li> <li>- Үйл ажиллагааг зохион байгуулахдаа ажилчдан санал хүсэлтийг тогтмол сонгож ажилдаа тусгаж ажиллаж хэвшүүлсэн.</li> <li>- Ажилчидтай ганцаарчилсан уулзалтыг хийж, ажил амьдралд нь тулгамдаж байгаа асуудлыг сонгож сэтгэл зүйн дэмжлэгийг тогтмол өгч ажиллаж хэвшсэн.</li> <li>- Ажлын бус цаг буюу хамт олны нийгмийн идэвхийг сайжруулах чиглэлээр спортын цаг, гэр бүлийн өдрийг сард 1 удаа тэмдэглэж тогтмолжуулсан.</li> <li>- Байгууллагын хийж хэрэгжүүлж</li> </ul>	95
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<p>Ажилчдын 2025 оны хийж хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр баталсан.</p> <p>Ажилчдын ажлын үр дүнг сар бүр дүгнэж, улирлаар нь урамшууллыг тооцож бодож олгож ажилласан ба 2025 онд урамшуулалд 55,5 сая төгрөг зарцуулсан ба байгууллагын төсвийн 5%-ийг эзэлж байна.</p>	100
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам		
Хэсгийн дундаж хувь:			96,2

Гурав:Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талгаарх			
3.1	Өмнөх он төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Байгууллагын үйл ажиллагааны 2026 оны төсвийн төслийг холбогдох заавар журмын дагуу боловсруулж хуулийн хугацаанд НЭМГ-т хүлээлгэн өгч ажилласан.	100
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Төсвийн улирлын гүйцэтгэл, санхүүгийн тайланг улирал бүр хуулийн заасан хугацаанд НЭМГ, дүүргийн ЗДТГ-т тайлагнаж ажилласан. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр тайлагнасан. Байгууллагын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот албан бичгээр Өлзийт Экаунт аудитын байгууллагад санхүүгийн тайланг хүргүүлэн ажилласан. Аудитын байгууллагаас шаардлагатай баримт, тодруулгыг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Аудитын байгууллагын дүгнэлт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг 19 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Анализ старт АУДИТ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханан эхний 3 улирлын санхүүгийн баримтанд аудит хийгдэж байгаа болон холбогдох баримтыг хугацаанд тухай бүр өгч мэдээллээр ханган иажиллаж байна.	100
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын вэб сайт болон шилэн дансанд байршуулсан.	100
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Төлбөртэй тусламж үйлчилгээ байхгүй	
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	2025 онд санхүүгийн өр төлбөргүй зохих зардал, санхүүгийн сахилга батыг баримталж ажилласан.	
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Байгууллагын санхүүгийн гүйлгээний худалдан авалтын мэдээллийг сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд мэдээллийг байршуулж мэдээлж ажилласан.	100
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансны сайтанд сар бүр тухай бүр байршуулж мэдээллийг бүрэн мэдээлж ажилласан.	100

	бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт		
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Санхүү, гүйлгээтэй холбоотой гарсан байгууллагын даргын тушаал шийдвэрийг сар бүр байршуулж ажилласан. Боловсон хүчний тушаалаас цалин нэмэгдэл бодогдох тушаал, төсөвтэй зохион байгуулах А тушаал зэргийг байршуулсан.	100
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Шилэн дансанд байршуулах 171 мэдээллээс хугацаа болоогүй 5 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 15, хугацаандаа мэдээлсэн 151 байршуулсан.	85
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	2025 онд тендер шалгаруулалт зохион байгуулаагүй.	0
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Байгууллагын 2024 оны санхүүгийн аудитын дүгнэлтээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан ба 2025 оны аудитыг хийлгэхээр холбогдох баримт, бичиг, тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	80
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжилт, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Хэрэгжээгүй	
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй	
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Хийгдсэн судалгаа шинжилгээ байхгүй	
3.15	Хууль тогтоомжид заасан бусад		
<b>Хэсгийн дундаж хувь:</b>			<b>95</b>

<b>Дөрөв: Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн</b>		80
4.1	<p>Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл</p> <p>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын даргын батласан 4 журам</li> <li>- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Иргэдэд хүргэх мэдээллийг тухай бүр байршуулсан.</li> </ul> <p>Тусгай зөвшөөрөл олгохгүй</p>
<b>Хэсгийн дундаж хувь:</b>		80
<b>Тав: Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал</b>		
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээны актын төсөл, тэдгээрийн танилцуулага, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал.	Олон нийтээр хэлэлцэж боловсруулж батласан журам байхгүй
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт.	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд 2025 онд шинээр боловсруулсан 2 журамд ажилчдын саналыг авч нэгтгэн журмыг бүх ажилчдын хурлаар нэгтгэлийг оруулж батлуулж хэрэгжүүлж ажилласан.
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл.	Байгууллагын эд хөрөнгө, өмчийн мэдээллийг санхүүгийн бүртгэл программ болон өмчийн харилцааны программд бүрэн мэдээллийг байршуулж ажилласан.
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл.	Байхгүй
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий хуулийн этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдалын тайлан, нэгдсэн	Байгууллагын вэб сайтанд дүүрэгт орон нутаг болон байгууллагын газар эзэмшлийн байршлыг байршуулж ажилласан.
		100

	төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг.		
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдалтын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшуулалын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтанд оролцогчдын талаарх мэдээлэл	Журам байхгүй	
5.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргасанаас орсон талаарх мэдээлэл.	Байхгүй	
5.8	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл.	Байхгүй	
5.9	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт.	Байхгүй	
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ.	Байхгүй	

5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл.	Байхгүй	
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардалын дүн, гэрээний хэрэгжилт.	Байхгүй	
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байхгүй	
Хэсгийн дундаж хувь:			92,5
Хэрэгжилтийн дундаж хувь			90,7



ХЯНАСАН  
ДАРГА

Х.ГАНБАТ

ТАЙЛАНГАРГАСАН

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТЖАРГАЛ